



Байнгын оршин суух эрх авахад өгдөг чех хэлний шалгалтын төвшин өөрчлөгдлөө.

2021 оны 9-р сарын 1-нээс байнгын оршин суух эрх авахад өгдөг чех хэлний шалгалтын төвшин өөрчлөгдөж байна. Чех хэлний төвшин А1-ээс А2 боллоо. Энэ нь 2021 оны 9-р сарын 1-нээс хойш байнгын оршин суух эрх хүссэн гадаад иргэд бүр дээд төвшний шалгалт өгөх ёстой юм.

АНХААР !!! Хэрвээ гадаад иргэн 2021 оны 9-р сарын 1-нээс өмнө байнгын оршин суух эрх хүсвэл, хүсэлт нь цуцлагдана. А1-ээр өгсөн шалгалтыг хүлээн зөвшөөрөхгүй байх боломжтой бөгөөд, хэрвээ тийм бол, 2021 оны 9-р сарын 1-нээс хойш дахин байнга оршин суух хүсэлт өгнө. Энэ үед та А2 төвшний шинэ шалгалт өгөх ёстой.

Шалгалт өгөхийн өмнө гадаад иргэд бүр Чех улсын бүх аймагт болон интеграцын төв эсвэл төрийн бүс байгууллагуудаас зохиогддог хэлний сургалтад явах боломжтой.

Шалгалтын үнэ 2500 КĚ. Эхний шалгалтыг Дотоод хэргийн яамны Орогнол болон цагаачлалын бодлогын газраас олгосон эрхийн бичгийн хэлбэрээр төлнө.

Хэрхэн шалгалтад бүртгүүлэх вэ?

Шалгалтыг дараах [сонгосон сургуулиудад](#) өгөх боломжтой. Бүртгэлийг та [цахимаар](#) эсвэл сонгосон сургууль дээр биеэрээ өгч болно. Бүртгүүлэхийн тулд таны гадаад паспорт хүчинтэй байх ёстой бөгөөд Чех улсад байнга орших суух зөвшөөр хүсэхэд зориулсан чех хэлний шалгалт үнэ төлбөргүй өгч болох эрхийн бичигтэй (poukaz) байх (OAMP MVČR авна). Шалгалтад орох хүн бүр бүртгэлийн дугаар авах бөгөөд, шалгалт өгөх өдөр паспорт болон бүртгэлийн дугаараа үзүүлж шалгуулна. Шалгалтын бичгийн болон ярианы хэсгийн өмнө биеийн байцаалтыг шалгана. Мөн ирцийн хуудас дээр гарын үсэг зурна. Шалгалтад хамрагдагч оройтлоо гэхэд 7 хоногийн өмнө биеэрээ очиж эсвэл захидлаар шалгалт өгөх сургууль руу бүртгэлээ цуцлуулж болно.

Чех хэлний А2 төвшний шалгалт ярианы болон бичгийн хэсгээс бүрдэнэ. Шалгалтын хоёр хэсгийг нэг өдөр авна.

Нэгдүгээр хэсэг нь бичгийн хэсэг бөгөөд хоёр хэсгээс бүрдэнэ :

- Тест – унших болон бичих, ойролцоогоор 65 минут (дараан завсарлана)
- Тест – сонсох, ойролцоогоор 35-40 минут

Шалгалтын бичгийн хэсэгт шалгалтад хамрагдагч:

- завсарлах болоогүй байхад шалгалтын танхимыг орхиж болохгүй
- электрон төхөөрөмж болон ном, толь бичиг хэрэглэж болохгүй
- ганцаараа шалгалтаа өгнө
- шалгалтын хариуг зөвхөн хариултын хуудсан дээр бичих бөгөөд бичих хэрэгслүүдийг сургуулиас өгнө
- тогтсон цагт даалгавар болон хариултын хуудсыг хураалгана



Шалгалтын ярианы хэсэг (ойролцоогоор 15 минут) дараах хэсгээс бүрдэнэ:

- асуултад хариулна
- зураг дээр үндэслэн даалгаврыг шийдвэрлэнэ

Шалгалтыг амжилттай өгсний нотолгоо болгож сургуулиас гэрчилгээ олгоно.

Амжилтгүй өгсөн хүн дахин шалгалт өгөх бөгөөд хоёр хэсгийг хоёулангийн өгнө.

Календарийн жилд дээд тал нь гурван удаа шалгалт өгөх боломжтой.

Чех хэлний мэдлэг сайн байх нь чухал, учир нь:

- мэдээллийг илүү сайн ойлгох боломжийг олгоно,
- бусад иргэдтэй идэвхтэй мөн бие даасан харилцааг бий болгоно,
- нийгмийн амьдралыг сайжруулна (хүрээлэн буй орчинд чиг баримжаатай, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход),
- өөрийг эрх, үүргийн талаар чиг баримжааг сайжруулах (орчуулагч болон бусад зуучлагч ашиглахгүйгээр).